# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

## 2020 оны 9 дүгээр сар

**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 9 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14%-иар буюу 1,470 сая ам.доллараар буурч 9,075 сая ам.доллар байв. Үүнд экспорт 13%-иар буюу 799 сая ам.доллараар, импорт 15%-иар буюу 671 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 128 сая ам.доллараар буурч 1,219 сая ам.долларын ашигтай гарлаа.

**Хүснэгт 1.** Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | Жилээр | | | Өөрчлөлт | | | | Эхний 9 сар | | | Өөрчлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2019 | 2018/2017 | | 2019/2018 | | 2018 | 2019 | 2020 | 2019/2018 | | 2020/2019 | |
| | | | | Дүн | Хувь | Дүн | Хувь | | | | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **Эргэлт** | **10,538** | **12,887** | **13,747** | **2,349** | **22%** | **861** | **7%** | **9,634** | **10,545** | **9,075** | **911** | **9%** | **(1,470)** | **-14%** |
| Экспорт | 6,201 | 7,012 | 7,620 | 811 | 13% | 608 | 9% | 5,283 | 5,946 | 5,147 | 663 | 13% | (799) | -13% |
| Импорт | 4,337 | 5,875 | 6,128 | 1,537 | 35% | 253 | 4% | 4,351 | 4,599 | 3,928 | 248 | 6% | (671) | -15% |
| **Тэнцэл** | **1,863** | **1,137** | **1,492** | **(726)** | | **355** | **31%** | **932** | **1,347** | **1,219** | **416** | **45%** | **(128)** | **-10%** |

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл**** 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 50 сая ам.доллараар буурч, 1,376 сая ам.долларын ашигтай гарсан байна.

**Зураг 1.** Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




**Зураг 2.** Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар




**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 58% буюу 5,227 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 1,063 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 19%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 23%-иар

**Зураг 3.** Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/




**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 2020 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2%-иар өсч, өмнөх сараас 4%-иар буурч 1.844-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс өсөхөд зэсийн баяжмал болон алтны экспортын үнэ өссөнөөр тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас буурахад алт болон чулуун нүүрсний экспортын үнийн бууралтаас голлон шалтгаалжээ.

**Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.*

*** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.*

**Экспорт** 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 13%-иар буюу 799 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 8 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 2 нэгж хувиар буурсан байна.

**Хүснэгт 2.** Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2018 | | | 2019 | | | 2020 | | | Δ (2019/2018) | | | Δ (2020/2019) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **1. Уул уурхай** | | **4,672** | **88%** | | **5,276** | **89%** | | **4,781** | **93%** | **604** | **13%** | **11%** | **(495)** | **-9%** | **-8%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 1,073 | 1,488 | 28% | 1,066 | 1,421 | 24% | 1,021 | 1,166 | 23% | (67) | -4% | -1% | (255) | -18% | -4% |
| 1.2. Чулуун нүүрс | 27,027 | 2,122 | 40% | 28,629 | 2,435 | 41% | 19,822 | 1,476 | 29% | 312 | 15% | 6% | (959) | -39% | -16% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | 4,812 | 316 | 6% | 4,842 | 272 | 5% | 2,380 | 86 | 2% | (44) | -14% | -1% | (186) | -68% | -3% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 5,315 | 240 | 5% | 6,134 | 422 | 7% | 6,253 | 463 | 9% | 182 | 76% | 3% | 41 | 10% | 1% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | 3,432 | 144 | 3% | 7,464 | 344 | 6% | 20,247 | 1,166 | 23% | 200 | 138% | 4% | 822 | 239% | 14% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 92 | 153 | 3% | 101 | 145 | 2% | 103 | 124 | 2% | (8) | -5% | 0% | (21) | -14% | 0% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 345 | 116 | 2% | 500 | 155 | 3% | 491 | 115 | 2% | 39 | 34% | 1% | (40) | -26% | -1% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 4 | 36 | 1% | 4 | 37 | 1% | 5 | 30 | 1% | 1 | 3% | 0% | (7) | -20% | 0% |
| 1.9. Гянтболдын хүдэр, баяжмал | 0 | 5 | 0% | 0 | 5 | 0% | 0 | 0 | 0% | (0) | -5% | 0% | (5) | -96% | 0% |
| 1.10. Мөнгө /тонн/ | 0 | 1 | 0% | 0 | - | 0% | 182,291 | 99 | 2% | (1) | | 0% | 99 | 0% | 2% |
| 1.11. Бусад | 374 | 50 | 1% | 116 | 40 | 1% | 62 | 54 | 1% | (11) | -21% | 0% | 14 | 36% | 0% |
| **2. Мал аж, ахуй** | 296 | **388** | **7%** | 247 | **402** | **7%** | 164 | **219** | **4%** | **14** | **4%** | **0%** | **(183)** | **-45%** | **-3%** |
| 2.1. Амьд мал, малын мах | 20 | 46 | 1% | 18 | 37 | 1% | 9 | 18 | 0% | (9) | -19% | 0% | (18) | -50% | 0% |
| 2.2. Арьс, шир | 252 | 13 | 0% | 208 | 11 | 0% | 141 | 6 | 0% | (1) | -12% | 0% | (5) | -44% | 0% |
| 2.3. Малын өлөн гэдэс | 0 | 6 | 0% | 0 | 6 | 0% | 0 | 6 | 0% | 0 | 5% | 0% | 0 | 5% | 0% |
| 2.4. Ноолуур | 8 | 299 | 6% | 8 | 327 | 6% | 7 | 180 | 3% | 28 | 9% | 1% | (147) | -45% | -2% |
| 2.5. Ноос, бусад үс, хялгас | 12 | 22 | 0% | 11 | 19 | 0% | 6 | 8 | 0% | (3) | -15% | 0% | (11) | -59% | 0% |
| 2.6. Бусад | 3 | 3 | 0% | 3 | 2 | 0% | 0 | 1 | 0% | (1) | -24% | 0% | (1) | -53% | 0% |
| **3. Газар тариалан** | 26 | **5** | **0%** | 34 | **8** | **0%** | 30 | **8** | **0%** | **2** | **47%** | **0%** | **0** | **5%** | **0%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | 182 | **217** | **4%** | 305 | **260** | **4%** | 174 | **138** | **3%** | **43** | **20%** | **1%** | **(122)** | **-47%** | **-2%** |
| 4.1. Хүнс | 16 | 47 | 1% | 17 | 42 | 1% | 13 | 34 | 1% | (5) | -11% | 0% | (8) | -19% | 0% |
| 4.2. Ноолууран эдлэл | 1 | 25 | 0% | 1 | 33 | 1% | 1 | 23 | 0% | 8 | 32% | 0% | (9) | -29% | 0% |
| 4.3. Бусад хувцас, гутал, эдлэл | 2 | 18 | 0% | 2 | 13 | 0% | 3 | 11 | 0% | (5) | -29% | 0% | (2) | -17% | 0% |
| 4.4. Уул уурхай | 43 | 82 | 2% | 118 | 81 | 1% | 14 | 41 | 1% | (2) | -2% | 0% | (39) | -49% | -1% |
| 4.5. Цахилгаан, электрон бараа | 0 | 2 | 0% | 0 | 1 | 0% | 0 | 1 | 0% | (1) | -69% | 0% | (0) | -6% | 0% |
| 4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анг | 2 | 39 | 1% | 1 | 87 | 1% | 2 | 25 | 0% | 47 | 121% | 1% | (62) | -71% | -1% |
| 4.7. Бусад | 118 | 4 | 0% | 166 | 5 | 0% | 142 | 4 | 0% | 1 | 38% | 0% | (1) | -26% | 0% |
| **5. Бусад** | 0 | **1** | **0%** | 0 | **1** | **0%** | 0 | **1** | **0%** | **(0)** | **-26%** | **0%** | **0** | **22%** | **0%** |
| **Нийт дүн** | | **5,283** | | | **5,946** | | | **5,147** | | **663** | **13%** | | **(799)** | **-13%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 3.** Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 9 сар

| Төрөл | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **1. Уул уурхай** | **(1)** | | **(494)** | | **(495)** | **-9%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | (52) | 20% | (203) | 80% | (255) | -18% |
| 1.2. Чулуун нүүрс | (656) | 68% | (303) | 32% | (959) | -39% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | (89) | 48% | (97) | 52% | (186) | -68% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 9 | 21% | 32 | 79% | 41 | 10% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | 736 | 90% | 86 | 10% | 822 | 239% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 2 | -12% | (23) | 112% | (21) | -14% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | (2) | 5% | (37) | 95% | (40) | -26% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 2 | -33% | (10) | 133% | (7) | -20% |
| 1.11. Бусад | (47) | -327% | 61 | 427% | 14 | 36% |
| **2. Мал аж, ахуй** | **(46)** | 25% | **(137)** | 75% | **(183)** | **-45%** |
| 2.1. Амьд мал, малын мах | (16) | 88% | (2) | 12% | (18) | -50% |
| 2.2. Арьс, шир | (3) | 60% | (2) | 40% | (5) | -44% |
| 2.4. Ноолуур | (12) | 8% | (135) | 92% | (147) | -45% |
| **3. Газар тариалан** | **(1)** | **-295%** | **1** | **395%** | **0** | **5%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | **(309)** | **254%** | **187** | **-154%** | **(122)** | **-47%** |
| **5. Бусад** | **(0)** | **-180%** | **0** | **11%** | **0** | **22%** |
| **Нийт дүн** | **(357)** | | **(442)** | | **(799)** | **-13%** |

** Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулж, нийт 799 сая ам.долларын бууралтыг харвал:

1/ Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 1 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 494 сая ам.доллараар буурчээ. Үүнд чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,214 сая ам.доллар болж буурахад голлон нөлөөлсөн. Харин алтны экспорт тоо хэмжээний болон үнийн өсөлттэй холбоотойгоор өнгөрсөн оны мөн үеэс 822 сая ам.доллараар өсөв.

2/ Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хувьд биет хэмжээний бууралтаас шалтгаалж 46 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан мөн 137 сая ам.доллараар буурсан.

**Зураг 4.** Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ




Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 9 дүгээр сард 1,944 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 29%-иар өссөн бол, өмнөх сараас 1%-иар буурав. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,681; 127 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 16%-иар, төмрийн хүдэр 36%-иар тус тус өссөн. Харин өмнөх сартай харьцуулбал, зэсийн болон төмрийн хүдрийн үнэ 3%, 5%-иар тус тус өсчээ. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 9 дүгээр сард 66 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 19%-иар, өмнөх сараас 8%-иар буурсан үзүүлэлттэй байна.

**Импорт** 2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15%-иар буюу 671 сая ам.доллараар буурав. Импортын 15 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

**Хүснэгт 4.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2018 | | | 2019 | | | 2020 | | | Δ (2019/2018) | | | Δ (2020/2019) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | | **1,182** | **27%** | | **1,230** | **27%** | | **1,109** | **28%** | **49** | **4%** | **1%** | **(121)** | **-10%** | **-3%** |
| Түргэн эдэлгээтэй | 714 | 617 | 14% | 666 | 621 | 14% | 701 | 629 | 16% | 4 | 1% | 0% | 8 | 1% | 0% |
| *Хүнс* | *343* | 429 | *10%* | *315* | 436 | *9%* | *334* | 442 | *11%* | *7* | *2%* | *0%* | *6* | *1%* | *0%* |
| *Эм, тариа* | *2* | 82 | *2%* | *2* | 77 | *2%* | *2* | 80 | *2%* | *(5)* | *-6%* | *0%* | *3* | *4%* | *0%* |
| *Бусад түргэн эдэлгээтэй бараа* | *369* | 106 | *2%* | *349* | 108 | *2%* | *364* | 108 | *3%* | *2* | *2%* | *0%* | *(0)* | *0%* | *0%* |
| Удаан эдэлгээтэй | 181 | 565 | 13% | *239* | 609 | 13% | *221* | 480 | 12% | 45 | 8% | *1%* | (129) | -21% | -3% |
| *Гутал, хувцас, цүнх* | *43* | 54 | *1%* | *50* | 50 | *1%* | *63* | 49 | *1%* | *(4)* | *-7%* | *0%* | *(1)* | *-1%* | *0%* |
| *Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга* | *76* | 84 | *2%* | *127* | 80 | *2%* | *91* | 76 | *2%* | *(4)* | *-4%* | *0%* | *(4)* | *-5%* | *0%* |
| *Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл* | *1* | 367 | *8%* | *1* | 414 | *9%* | *1* | 287 | *7%* | *48* | *13%* | *1%* | *(128)* | *-31%* | *-3%* |
| *Бусад удаан эдэлгээтэй бараа* | *60* | 60 | *1%* | *61* | 65 | *1%* | *66* | 68 | *2%* | *4* | *7%* | *0%* | *3* | *4%* | *0%* |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | *1,140* | **1,798** | **41%** | *989* | **1,999** | **43%** | *1,069* | **1,749** | **45%** | **201** | 11% | **5%** | **(250)** | **-13%** | **-5%** |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд анги | 25 | 1,127 | 26% | 21 | 1,314 | 29% | 28 | 1,076 | 27% | 187 | 17% | 4% | (239) | -18% | -5% |
| *Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги* | 1 | 353 | *8%* | 2 | 473 | *10%* | 7 | 385 | *10%* | *120* | *34%* | *3%* | *(88)* | *-19%* | *-2%* |
| *Машин механик, тоног төхөөрөмж, эд анги* | 24 | 774 | *18%* | 19 | 842 | *18%* | 22 | 691 | *18%* | *67* | *9%* | *2%* | *(151)* | *-18%* | *-3%* |
| Барилгын материал | 621 | 512 | 12% | 795 | 523 | 11% | 1,032 | 480 | 12% | 11 | 2% | 0% | (43) | -8% | -1% |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа | 31 | 157 | 4% | 36 | 161 | 4% | 92 | 193 | 5% | 4 | 3% | 0% | 32 | 20% | 1% |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | 1,185 | **553** | **13%** | 1,365 | **507** | **11%** | 1,319 | **483** | **12%** | **(45)** | **-8%** | **-1%** | **(24)** | **-5%** | **-1%** |
| Хүнсний орц | 271 | 73 | 2% | 39 | 19 | 0% | 147 | 39 | 1% | (55) | -75% | -1% | 21 | 111% | 0% |
| Химийн бүтээгдэхүүн | 154 | 92 | 2% | 170 | 91 | 2% | 149 | 84 | 2% | (1) | -1% | 0% | (7) | -8% | 0% |
| Даавуу, утас, арьс, савхин эдлэл | 57 | 22 | 1% | 58 | 21 | 0% | 54 | 19 | 0% | (1) | -3% | 0% | (3) | -14% | 0% |
| Цахилгаан эрчим хүч | 1 | 105 | 2% | 1 | 108 | 2% | 1 | 104 | 3% | 2 | 2% | 0% | (3) | -3% | 0% |
| Металлын хүдэр, баяжмал болон хаягдал | 0 | 1 | 0% | 1 | 1 | 0% | 1 | 1 | 0% | 0 | 5% | 0% | 0 | 21% | 0% |
| Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай | 656 | 260 | 6% | 720 | 268 | 6% | 717 | 237 | 6% | 8 | 3% | 0% | (31) | -12% | -1% |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **1,185** | **815** | **19%** | **1,365** | **858** | **19%** | **1,319** | **583** | **15%** | **43** | **5%** | **1%** | **(275)** | **-32%** | **-6%** |
| Дизель түлш | 630 | 414 | 10% | 824 | 507 | 11% | 720 | 305 | 8% | 94 | 23% | 2% | (203) | -40% | -4% |
| АИ-92, АИ-95 | 271 | 191 | 4% | 350 | 211 | 5% | 377 | 158 | 4% | 20 | 10% | 0% | (53) | -25% | -1% |
| А-80 болон бусад | 283 | 210 | 5% | 190 | 140 | 3% | 222 | 121 | 3% | (70) | -33% | -2% | (19) | -14% | 0% |
| **Бусад** | **13** | **5** | **0%** | **5** | **4** | **0%** | **178** | **3** | **0%** | **(1)** | **-18%** | **0%** | **(1)** | **-20%** | **0%** |
| **Нийт дүн** | | **4,352** | | | **4,599** | | | **3,928** | | **247** | **6%** | | **(671)** | **-15%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 5.** Импортын өөрчлөлт, 2020 он эхний 9 сар

| Төрөл* | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | **(21)** | **17%** | **(100)** | **83%** | **(121)** | **-10%** |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэх** | **620** | **-248%** | **(870)** | **348%** | **(250)** | **-13%** |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | **12** | | **(36)** | | **(24)** | **-5%** |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **(16)** | **6%** | **(259)** | **94%** | **(275)** | **-32%** |
| Дизель түлш | (44) | 22% | (159) | 78% | (203) | -40% |
| АИ-92, АИ-95 | 11 | -22% | (64) | 122% | (53) | -25% |
| А-80 болон бусад | 17 | -90% | (36) | 190% | (19) | -14% |
| **Бусад** | **3** | | **(4)** | | **(1)** | **-20%** |
| **Нийт дүн** | **600** | **-89%** | **(1,270)** | **189%** | **(671)** | **-15%** |

** Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/




2020 оны эхний 9 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт импорт 671 сая ам.доллараар буурчээ. Үүнд:

- Машин, механик тоног төхөөрөмжийн импорт буюу хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 250 сая ам.доллараар,
- Дизель түлшний хэрэглээтэй холбоотойгоор нефтийн бүтээгдэхүүний импорт 275 сая ам.доллараар,
- Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 121 сая ам.доллараар,
- Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 24 сая ам.доллараар тус тус буурчээ.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 29%-иар буурсан хэдий ч өмнөх сараас 13%-иар өсч тонн тутамд 441 ам.долларт хүрэв.